



МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 9 сарын 03 өдөр

Дугаар 168

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Татварын ерөнхий хуулийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсгийг үндэслэн  
ТУШААХ нь:

1. "Татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгох журам"-ыг  
хавсралт ёсоор баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг зохион байгуулан, хяналт тавьж ажиллахыг  
Татварын ерөнхий газар /Б.Заяабал/-т үүрэг болгосугай.



Ч.ХҮРЭЛБААТАР

Сангийн сайдын 2020 оны 9 дүгээр сарын  
09-ний өдрийн 168 дүгээр тушаалын хавсралт

ТАТВАРЫН УЛСЫН БАЙЦААГЧИД  
ҮР ДҮНГИЙН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Энэ журмын зорилго нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах, төсвийн орлого бүрдүүлэх ажлыг сайжруулах хүрээнд тодорхой үр дүн гаргасан, онц чухал ач холбогдол бүхий ажлын хэсэгт орж ажилласан татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Татварын улсын байцаагчийн үр дүнгийн шагналыг сар бүр олгож болох бөгөөд хэмжээ нь тухайн албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна.

1.3. Ажлын үр дүнгийн шагналд шаардагдах хөрөнгийг татварын албаны жил бүрийн төсөвт тусгана.

Хоёр. Татварын улсын байцаагчид үр дүнгийн шагнал олгох

2.1. Татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах, хөнгөлөх, чөлөөлөх, суутган тооцох, буцаан олгох болон хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж нэвтрүүлсэн, ажлын байранд сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй энэ журмын 2.4-т заасны дагуу баталсан аргачлалд заасан шалгуурыг хангасан татварын улсын байцаагчид дараах хувиар үр дүнгийн шагнал олгоно:

2.1.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн татварын газар, хэлтэс, тасгийн татварын улсын байцаагчид энэ журмын 2.4-т заасан шалгуур үзүүлэлтийг үндэслэн тухайн татварын газар, хэлтсийн дарга сарын үндсэн цалингийн 20 хүртэл хувиар;

2.1.2. Татварын ерөнхий газрын харьяа нэгжийн татварын улсын байцаагчид энэ журмын 2.4-т заасан шалгуур үзүүлэлтийг үндэслэн тухайн нэгжийн дарга сарын үндсэн цалингийн 20 хүртэл хувиар;

2.1.3. Татварын ерөнхий газрын татварын улсын байцаагч, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн дарга бөгөөд татварын улсын байцаагчид энэ журмын 2.4-т заасан шалгуур үзүүлэлтийг үндэслэн Татварын ерөнхий газрын дарга сарын үндсэн цалингийн 20 хүртэл хувиар;

2.2.Татварын ерөнхий газрын дарга нь энэ журмын 2.4-т заасан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангалттай үзүүлж төлөвлөгөөнд тусгагдсанаас давуулан ногдол нэмэгдүүлсэн эсхүл татварын өр барагдуулсан татварын улсын байцаагчид үр дүнгийн шагналыг Татварын ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн сарын үндсэн цалингийн 30 хүртэл хувиар шагнал нэмж олгож болно.

2.3.Энэ журмын 2.1.1-д заасан шагналыг тухайн татварын газар, хэлтсийн даргын, 2.1.2-т заасан шагналыг тухайн нэгжийн даргын, 2.1.3, 2.2-т заасан үр дүнгийн шагналыг Татварын ерөнхий газрын даргын тушаалаар тус тус олгоно.

2.4.Энэ журамд нийцүүлэн татварын улсын байцаагчийн ажлын үр дүнг тооцох, шагнал олгох шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалыг Татварын ерөнхий газрын дарга батална.

#### Гурав. Бусад зүйл

3.1.Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн албан хаагчид сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуустал үр дүнгийн шагнал олгохгүй.

-оОо-